



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 4 сарын 28 өдөр

Дугаар A-76

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан)-т, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т тус тус үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

Монголбанкны Ерөнхийлөгчийн
2015 оны ... дугаар сарын ... ны өдрийн
А. ... дугаар тушаалын хавсралт

**ТӨЛБӨРИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ ОРЛОЦОГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭР НЬ
ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ**

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан төлбөрийн системд хамаарах бодлогын баримт бичиг, журам, заавар, холбогдох шаардлагыг төлбөрийн систем, түүний оролцогч хэрхэн хэрэгжүүлж байгааг газар дээр нь шалгаж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчилд арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Төлбөрийн системийн үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалтыг Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид “ТТБГ” гэх)-аас хийж гүйцэтгэнэ.

II. ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХЭЛБЭР

- 2.1. Шалгалтын зорилго нь төлбөрийн систем, түүний оролцогчийн төлбөрийн системтэй холбоотой үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, Монголбанкнаас тавьсан шаардлагад нийцэж буй эсэхийг газар дээр нь шалгаж, баримт материалд үндэслэн дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах замаар төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 2.2. Газар дээр хийх шалгалтыг урьдчилан төлөвлөсний дагуу (төлөвлөгөөт) эсхүл гэнэтийн хэлбэрээр гүйцэтгэж болно.
 - 2.2.1. Хянан шалгагч нь төлөвлөгөөт шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн хүрээнд оролцогчид урьдчилан мэдэгдсэнээр хийнэ.
 - 2.2.2. Шалгалтын удирдамжийг энэхүү журмын хавсралтын дагуу бэлтгэн, Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулна.
 - 2.2.3. Хянан шалгагч нь тодорхой мэдээлэлд үндэслэн, удирдлагад танилцуулсны үндсэн дээр эсхүл удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гэнэтийн шалгалтыг оролцогчид урьдчилан мэдэгдэлгүйгээр хийнэ.
 - 2.2.4. Нөхцөл байдлаас шалтгаалан, шаардлагатай гэж үзвэл гэнэтийн шалгалтыг газрын захирлын баталсан удирдамжийн дагуу хийж болно.

III. ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ЧИГЛЭЛ

- 3.1. Төлбөрийн системийн шалгалт нь их, бага дүнтэй төлбөр тооцооны систем, картын нэгдсэн сүлжээ болон санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцооны систем, төлбөрийн системд нөлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн бусад төлбөр тооцооны систем, түүний оролцогч болон үйл ажиллагааг хамарна.
 - 3.1.1. Төлбөрийн системийн оролцогч гэдэгт банкууд, Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллага, Хөгжлийн банк хамрагдана.
- 3.2. Шалгалтыг хамрах хүрээгээр нь иж бүрэн ба хэсэгчилсэн шалгалт гэж ангилна.
 - 3.2.1. Иж бүрэн шалгалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан хуваарь, удирдамжийн хүрээнд хийх ба оролцогчийн төлбөрийн системтэй холбоотой үйл ажиллагааг бүхэлд нь шалгаж, дүгнэлт өгнө.
 - 3.2.2. Хэсэгчилсэн шалгалтыг оролцогч, хувь хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр эсхүл Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн оролцогчийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг шалгаж, дүгнэлт өгөх зорилгоор хийнэ.
- 3.3. Шалгалтыг дараах үндсэн чиглэлээр хийнэ:
 - 3.3.1. Төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагаа:
 - 3.3.1.1. Оролцогч нь төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж буй эсэх;
 - 3.3.1.2. Их болон бага дүнтэй төлбөр тооцоо, картын төлбөр тооцоо нь холбогдох журам, заавар, гэрээний дагуу хийгдэж буй эсэх;
 - 3.3.1.3. Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар, гэрээний шаардлагыг хангаж байгаа эсэх;
 - 3.3.1.4. Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт;
 - 3.3.1.5. Холбогдох бусад.
 - 3.3.2. Төлбөр тооцооны системийн үйл ажиллагаа:
 - 3.3.2.1. Их дүнтэй төлбөр тооцооны системийн үйл ажиллагаа нь холбогдох журам, заавар, хамтран ажиллах гэрээний дагуу явагдаж буй эсэх;
 - 3.3.2.2. Бага дүнтэй төлбөр тооцооны системийн үйл ажиллагаа нь холбогдох журам, заавар, хамтран ажиллах гэрээний дагуу явагдаж буй эсэх;
 - 3.3.2.3. Картын төлбөр тооцооны системийн үйл ажиллагаа нь холбогдох журам, заавар, хамтран ажиллах гэрээний дагуу явагдаж буй эсэх;
 - 3.3.2.4. Холбогдох бусад

3.3.3. Төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцооны үйлчилгээний зөвшөөрөл, дүгнэлт:

- 3.3.3.1. Ашиглаж буй төлбөрийн хэрэгсэл, үзүүлж буй төлбөр тооцооны үйлчилгээ нь Монголбанкнаас холбогдох зөвшөөрөл авч, дүгнэлт хийлгэсэн эсэх, олгосон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;
- 3.3.3.2. Төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцооны үйлчилгээ нь Монголбанкнаас гаргасан журам заавар, стандарт, шаардлагуудыг хангаж буй эсэх;
- 3.3.3.3. Холбогдох бусад.

3.3.4. Төлбөр тооцооны системийн техник хангамж, програм хангамж, нууцлал, аюулгүй байдал:

- 3.3.4.1. Техник болон програм хангамж, сүлжээний тоног төхөөрөмж нь холбогдох журам, заавар, хамтран ажиллах гэрээнд заасан шаардлагуудыг хангаж буй эсэх;
- 3.3.4.2. Төлбөр тооцооны системийн хэвийн ажиллагааг ханган ажиллах хүчин чадалтай эсэх;
- 3.3.4.3. Төлбөр тооцооны системээр дамжиж байгаа болон хадгалагдаж буй төлбөр тооцооны болон хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж буй эсэх;
- 3.3.4.4. Холбогдох бусад.

3.3.5. Системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлт:

- 3.3.5.1. Их, бага дүнтэй төлбөр тооцооны систем, тэдгээрийн оролцогч нь төлбөрийн системийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, хяналтын системтэй эсэх;
- 3.3.5.2. Онцгой байдлын үед ажиллах багийг бүрдүүлсэн эсэх;
- 3.3.5.3. Төлбөрийн системийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор нөөц төв байгуулан ажиллаж буй эсэх;
- 3.3.5.4. Онцгой байдлын төлөвлөгөөний дагуу тодорхой хугацааны давтамжтай туршилт хийдэг эсэх;
- 3.3.5.5. Оролцогчийн системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт нь Монголбанкнаас гаргасан төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцооны үйлчилгээний шаардлагуудыг хангаж буй эсэх;

3.3.6. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн, төлбөрийн системд хамаарах бусад үйл ажиллагаа.

3.4. Тодорхой мэдээллийн мөрөөр эсхүл удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу гэнэтийн шалгалт хийхдээ зөвхөн тухайн мэдээлэлтэй холбоотой баримт, материалыг шалгана.

IV. ХЯНАН ШАЛГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Хянан шалгагч нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны улсын байцаагчийн дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.2. Шалгалтын явцад шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбар, төлөөлөгчийн газрын хянан шалгагчийг татан оролцуулж болно.
- 4.3. Хянан шалгагч нь илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор оролцогчид шаардлага тавих, хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг хянах, үр дүнг хангуулах арга хэмжээ авна.

V. ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ, ТАЙЛАГНАХ

- 5.1. Шалгалт хийх ажлын хэсэг нь ажлын хэсгийн ахлагч болон гишүүдээс бүрдэнэ.
- 5.2. Ажлын хэсгийн ахлагч нь шалгалт хийснээс хойш ажлын 10 өдрийн дотор ажлын хэсгийн гишүүдийн бичсэн акт материал, дүгнэлт, саналыг эцэслэн нэгтгэсэн шалгалтын тайланг бэлтгэж, цаашид хийх шаардлагатай ажил, авах арга хэмжээний талаарх саналын хамт Монголбанкны удирдлагад танилцуулна.
- 5.3. Шалгалтын тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна.
 - 5.3.1. Шалгалтын зорилго, хэлбэр, хамрах хүрээ, чиглэл, шалгалт хийсэн огноо;
 - 5.3.2. Шалгалтын явцад илэрсэн зөрчилтэй үйл ажиллагаа, зөрчил гаргасан этгээдийн нэр, албан тушаал, зөрчигдсөн хууль тогтоомжийн заалт;
 - 5.3.3. Шалгалтын ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, авах арга хэмжээ болон цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх санал, зөвлөмж;
 - 5.3.4. Хууль тогтоомж зөрчсөнийг нотлох баримт материалд үндэслэн ногдуулсан Улсын байцаагчийн акт, мэдэгдэл, шийтгэвэр;
 - 5.3.5. Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, засаж залруулах талаар шуурхай арга хэмжээ авсан бол тайлбар;
 - 5.3.6. Шалгалтын явцад санал, гомдол хүлээн авсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар;
 - 5.3.7. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар нотлох баримт бүхий тайлбар, дүгнэлт.

VI. ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 6.1. Шаардлагатай гэж үзвэл Монголбанк нь эрх бүхий байгууллагатай хамтран оролцогчийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт, шалгалт хийж болно.

VII. ХАРИУЦЛАГА

- 7.1. Шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээний үндэслэлийг хянан шалгагч өөрөө хариуцах ба ногдуулсан арга хэмжээ, захиргааны шийтгэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 7.2. Холбогдох хууль тогтоомж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журам, зааврыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны Улсын байцаагч бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авч, зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл ногдуулна.

_____оОо_____

“Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ын хавсралт

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭР НЬ ХИЙХ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

... оны ... дугаар сарын
...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монголбанкны ТТБГ-аас төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь хийх шалгалтыг энэхүү удирдамжийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 1.2 Шалгалтын зорилго нь (цаашид "оролцогч" гэх)-ны төлбөрийн системтэй холбоотой үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавартай нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтад үндэслэн шалган тогтоож, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, хариуцлага ногдуулах замаар төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг баталгаажуулахад оршино.
- 1.3 Шалгалтын хэлбэр:
 - Иж бүрэн
 - Хэсэгчилсэн
- 1.4 Шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн:
 - Ажлын хэсгийн ахлагч
 - Ажлын хэсгийн гишүүд
- 1.5 Оролцогч нь шаардлагатай тайлан мэдээ, төлбөр тооцооны баримт, материалыг ажлын хэсэгт шаардсан хугацаанд нь саадгүй гаргаж өгөх, бүртгэлийн болон бусад холбогдох програм хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангана.
- 1.6 Ажлын хэсгийн ахлагч нь шалгалтыг тогтоосон хугацаанд үр дүнтэй хийж гүйцэтгэхэд ажлын хэсгийг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ шалгалтын явц, дүнгийн талаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шалгалтын удирдамжид өөрчлөлт оруулах талаар саналаа Монголбанкны удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

ХОЁР. ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. “Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам”-ын 3 дугаар бүлэгт заасан хамрах хүрээ, чиглэлээр тодорхойлогдоно.

ГУРАВ. ШАЛГАЛТЫН ДҮНГ ГАРГАХ

- 3.1. Шалгалтын явцад Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу ажлын хэсгийн гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж, зөрчил, дутагдлыг залруулах арга хэмжээ авч ажиллана.
- 3.2. Ажлын хэсгийн ахлагч удирдамжийн дагуу шалгалт хийсэн тухай тайлан, материал бэлтгэж, шалгалтын дүгнэлт, авсан арга хэмжээний талаар шалгалт хийж дууссанаас хойш ажлын ... өдрийн дотор Монголбанкны удирдлагад танилцуулна.
- 3.3. Шалгалтын тайланг удирдлагад танилцуулснаас хойш ажлын ... өдрийн дотор оролцогч бүрт тухайн оролцогчид хамаарах шалгалтын үр дүнгийн талаар мэдэгдэнэ.

_____оОо_____